


Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар

Үндэсний Аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, удирдамжийн дагуу хийсэн нийцлийн аудитын тайлан

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН



АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ 69%-ТАЙ БАЙНА.

Алтай хот

2018 он

Аанг

Огноо: 2018 оны 11 дүгээр сар

Аймаг дахь
төрийн аудитын газрын
III баг

Дарга, Тэргүүлэх аудитор
Х.Түвшинбаяр
Утас: 99489309

Аудитын менежер
Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677

Ахлах аудитор
Д.Цэрэнханд
Утас: 99147999

Аудитор:
Г.Цэцэгмаа
Утас: 99489399

Шинжээч:
Ц.Сайханжаргал
Утас: 88665099

2018 оны 11 дүгээр сар

Аймаг дахь
төрийн аудитын газрын
III баг
Утас: 70483413,
70484055
70484030
Төрийн аудитын газрын III баг

Огноо:
Аймаг дахь
төрийн аудитын газрын
III баг

Товчилсон үгсийн жагсаалт.....	2
Аудит хийх үндэслэл, зорилт, хамрах хүрээ, арга зүй.....	3
Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт.....	4
Үндсэн мэдээлэл.....	5

НЭГ: Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд бүрэн хамрагдаж, хуульд заасан мэдээллийг 70 хувьтай мэдээлжээ.

1.1 Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Мал хамгаалах сан, ЖДҮД сан хамрагдаагүй, хамрагдсан 211 байгууллагууд хуульд заасан мэдээллийг 70%-тай мэдээлжээ.

1.2 Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчид шилэн дансны мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт 43 хувьтай мэдээлжээ.

1.3 Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэхийг УАГ дээр авч үзнэ.

ХОЁР: хуулийн 3.1.4-д заасан байгууллагын 84 хувь санхүүжүүлэгч байгууллагын цахим хуудсанд мэдээлсэн, 3.1.5-д заасан байгууллагын 80 хувь хамрагдаж, мэдээллийн 68 хувийг мэдээлсэн байна.

2.1 Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани байхгүй

2.2 Хуулийн 3.1.4 буюу Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа ААНБ-ийн 84 хувь нь санхүүжүүлэгч байгууллагын цахим хуудсанд мэдээлсэн, 16 хувь нь мэдээлээгүй байна.

2.3 Хуулийн 3.1.5 буюу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчид шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 80 хувьтай хамрагдаж, хуульд заасан мэдээллийг 68 хувьтай мэдээлсэн байна.

ГУРАВ: Бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурал хяналтыг хэрэгжүүлээгүй, санхүү хяналт аудитын алба цахимаар хяналт хийсэн боловч зөрчил арилаагүй, давтан гарсаар байна.

3.1 Хуулийн 8.1 буюу бүх шатны ИТХ-ийн хяналт хийгээгүй, хуулийн 8.2-т заасан Санхүү, хяналт аудитын албан хяналтыг цахимаар хэрэгжүүлж, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг хүргүүлсэн боловч хэрэгжилт 47.9 хувьтай хангалтгүй байна

3.2 Хуулийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд цахимаар хяналт хийсэн боловч үр дүнгүй байна.

3.3 Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаар иргэд, олон нийт мэдэхгүй, энэ талаарх мэдээлэл дутмаг байна.

3.4 Зөрчил давтан гарсаар байгаа нь өмнөх шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЗГ	Засгийн газар
ГАА	Говь Алтай аймаг
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
БИНХ	Багийн Иргэдийн Нийтийн хурал
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НДС	Нийгмийн даатгалын сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
АЗЗА	Авто замын засвар арчлалт
ГИДЦГХЗ	Говийн их дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭЭС	Эмийн эргэлтийн сан
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв

Дүрслэл, хүснэгтийн тайлбар

Дүрслэл № 1: Хуулийн 6.1.3 -6.1.6-д заасан мэдээллийг мэдээлсэн байдал /тоо/

Дүрслэл № 2: Хуулийн 6.1.3 - 6.1.6-д заасан мэдээллийг мэдээлээгүй байгууллагын тоог өмнөх онтой харьцуулбал:

Дүрслэл № 3: Мэдээллийн самбарт мэдээлсэн судалгаа

Дүрслэл № 4: Иргэдээс авсан санал асуулгын нэгтгэл

Дүрслэл № 5: Сүүлийн 3 жилийн зөрчлийг харьцуулсан судалгаа /тоогоор/

Дүрслэл № 6: Сүүлийн 3 жилийн зөрчлийг харьцуулсан судалгаа /сая.төгрөг/

Хүснэгт № 1: Хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд, тэдгээрийн шилэн дансанд оруулсан судалгаа

Хүснэгт № 2: Сангуудын мэдээлэгдээгүй орлого, зарлага

Хүснэгт № 3: Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь заалт, УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2017 оны 06 дугаар тогтоолыг үндэслэн Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д нийцлийн аудит хийлээ.

Аудитын зорилт

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ.

- ✚ Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд шилэн дансны цахим хуудсанд хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх
- ✚ Хуулийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хамрагдаж, хуульд заасан мэдээллийг мэдээлсэн эсэх
- ✚ Шилэн дансны тухай хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлсэн эсэх

Аудитын хамрах хүрээ

Аудитад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан хуулийн этгээд байгууллага, албан тушаалтан хамрагдах бөгөөд дараах баримт материалыг хамруулан шалгаллаа. Үүнд:

- Шилэн дансны цахим хуудас болон мэдээллийн самбарт тавьсан мэдээллүүд
- Байгууллагуудын сар бүрийн төрийн сангийн харилцах дансны хуулга, төлбөрийн хүсэлт /2017 оны 10 дугаар сарын 01-ээс 2018 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар/
- Аудитын дүгнэлт, шийдвэр, аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний ажлын тайлан /2017 оны 10 дугаар сарын 01-ээс 2018 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар/
- Байгууллагын батлагдсан орон тоо, төсөв /өөрчлөлт орсон тухай бүрд/
- Байгууллагын даргын тушаал /өр авлага, хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрүүд 2017 оны 10 дугаар сарын 01-ээс 2018 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар/
- ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажлуудын тендер шалгаруулалтын мэдээлэл, санхүүжүүлсэн байдал /2017 оны 10 дугаар сараас 2018 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар/
- ОНТХО-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажлуудын тендер шалгаруулалтын мэдээлэл, санхүүжүүлсэн байдал /2017 оны 10 дугаар сарын 01-ээс 2018 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар/
- СХС-гийн дансны хуулга /2017 оны 10 дугаар сарын 01-ээс 2018 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар/
- Иргэд, сумын ИТХ, БИНХ-ын шилэн дансны цахим хуудсанд хяналт шалгалт хийсэн материалууд, өгсөн үүрэг даалгавар, түүний биелэлт

- Иргэд олон нийтээс авсан санал асуулга
- Аудитын газраас өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт

Үндсэн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг, зорилго

Энэ хуулийн зорилт нь улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

Аудитын стандартын талаарх мэдэгдэл

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болгоно.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Засгийн газрын 2016 оны 29-р тушаал “Журам батлах тухай”
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

Аудитад ашигласан арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, нийцлийн аудитын төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу дараах арга зүйг ашиглалаа.

- Холбогдох байгууллагуудын жилийн батлагдсан төсөв, тодотгосон төсвийг шилэн дансанд мэдээлсэн төсөвтэй тулган баталгаажуулсан
- Тухайн онд тендер зарласан, ХАА явуулсан баримт бичгийг шилэн данс мэдээллийн самбарт мэдээлсэн мэдээлэлтэй тулган баталгаажуулсан
- Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, тухайн онд хүрэх түвшний үзүүлэлттэй танилцан, мэдээлсэн эсэхийг тулган үзсэн
- Дансны хуулгыг авч, төсвийн гүйцэтгэлийн дүнг 09 дүгээр сарын 30-ны байдлаар үнэн зөв мэдээлсэн эсэхийг анхан шатны баримт материалтай тулган баталгаажуулж, холбогдох албан тушаалтнаар гарын үсэг зуруулж хүлээн зөвшөөрүүлсэн
- Байгууллагын өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэхтэй холбоотой шийдвэрүүдтэй танилцан, мэдээлсэн эсэхийг тулган баталгаажуулсан
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн талаарх тушаал шийдвэртэй танилцан, мэдээлсэн эсэхийг үзсэн.
- Холбогдох албан тушаалтантай ярилцлага хийж, ГАА дахь Төрийн аудитын газрын дэргэдэх “Иргэдийн бүлэг”-тэй хамтран иргэд, олон нийтээс санал асуулга авч ярилцлага хийсэн.
- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10.0 сая төгрөгөөс дээш ажил, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, ААН-ийн санхүүжилтийн талаарх мэдээллийг тулган баталгаажуулсан.
- Тусгай сангуудын хуулгыг авч, шилэн дансны цэсэнд оруулсан эсэхийг тулгасан.

- Шилэн дансны тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш авч хэрэгжүүлсэн төлөвлөгөөт ажлууд, хяналт шалгалтын материалуудтай танилцсан
- Өмнөх шийдвэрийн хэрэгжилтийг газар дээр нь үзэх зэрэг аудитын горимуудыг ашигласан.

Үндсэн мэдээлэл:

Шилэн дансны тухай хууль 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн байна.

Аймгийн хэмжээнд хуулийн 3.1.1-д заасан 204 байгууллага 3.1.2-т заасан 7 байгууллага, 3.1.5-д заасан 5 байгууллага байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар аудит хийх бүртээ дэд асуудал болгон авч үзэж тайланд оруулан шийдвэр гаргаж байна.

Манай байгууллага нь тус хуулийн хэрэгжилтэд 2015 онд хийсэн аудитаар 4,071.4 сая төгрөг, 2016 оны эхний 1 дүгээр улирлын байдлаар хийсэн аудитаар 2,540.6 сая төгрөг, 3 дугаар улирлын байдалд хийсэн аудитаар 5,924.4 сая төгрөг, 2017 оны 3 дугаар улирлын байдлаар хийсэн аудитаар 12,150.3 сая төгрөгийн зөрчил илрүүлэн холбогдох шийдвэрийг албан тушаалтанд хүргүүлсэн байна.

БҮЛЭГ I: ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 3 ДУГААР ЗҮЙЛИЙН 3.1.1, 3.1.2-Т ЗААСАН БАЙГУУЛЛАГУУД БҮРЭН ХАМРАГДАЖ, ХУУЛЬД ЗААСАН МЭДЭЭЛЛИЙГ 70 ХУВЬТАЙ МЭДЭЭЛЖЭЭ.

1.1 Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Мал хамгаалах сан, ЖДҮД сан хамрагдаагүй, хамрагдсан 211 байгууллагууд хуульд заасан мэдээллийг 70%-тай мэдээлжээ.

Аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасны дагуу хамрагдах 204 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнээс 204 байгууллага нь шилэн дансны нэгдсэн систем болох www.shilendans.gov.mn сайтад өөрийн цэсийг нээлгэсэн байна.

Харин аймгийн Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Мал хамгаалах сан, ЖДҮД сангууд нь тусдаа цахим хуудас нээлгээгүй, сангуудын талаарх мэдээлэл тавигдаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.2, 3.2.3 дахь заалтад “орон нутгийн хөгжлийн сан”, “Засгийн газрын тусгай сан”-гийн гүйцэтгэлийг мэдээлэхээр заасан боловч нэгдсэн цахим хуудсанд бие даасан цэстэй байх талаар тодорхой тусгаагүй байна.

Хүснэгт №1: Хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд, тэдгээрийн шилэн дансанд оруулсан судалгаа

Шилэн дансанд орох нийт байгууллагын тоо	207	Шилэн дансанд орсон нийт байгууллагын тоо	204
3.1.1-д заасан байгууллагууд		3.1.1-д заасан цахимд орсон байгууллагууд	
Үүнээс: Төрийн өмчит хуулийн этгээд	38	Үүнээс: Төрийн өмчит хуулийн этгээд	35
Орон нутгийн өмчит хуулийн этгээд	164	Орон нутгийн өмчит хуулийн этгээд	164
Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	5	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	5
3.1.2-д заасан байгууллагууд		3.1.2-д заасан цахимд орсон байгууллагууд	
Төрийн өмчит үйлдвэрийн газрууд	7	Төрийн өмчит үйлдвэрийн газрууд	7
Нийт дүн	214	Нийт дүн	211

Төрийн өмчит хуулийн этгээдээс Алтай сум дахь Хилийн цэргийн 0214-р анги, Зэвсэгт хүчний 304-р тусгай салбар нь зарим нууцын зэрэглэлтэй мэдээллээ оруулаагүй байна. Эдгээр байгууллагын үйл ажиллагаа нь Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Батлан хамгаалах салбарын нууцалбал зохих асуудлын хүрээнд багтах тул уг хуулийн үйлчлэлд хамаарахгүй болно.

Тодруулга: Аймгийн хэмжээнд Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан нь тусдаа бие даасан цэс үүсгээгүй бөгөөд аймаг, сумын нэгдсэн цэсэд тус сангуудын мэдээллийг оруулсан байна.

Эмийн эргэлтийн сангийн цэс 17 сумдад, халамжийн сан, нийгмийн даатгалын сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан гэсэн 20 сангийн бие даасан цэс үүсгэсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т заасан “Алтай” нисэх буудал”, Говь-Алтай “АЗЗА” ТӨХК, Радио телевизийн сүлжээний газар ТӨҮГ, “Алтай-Улиастай” эрчим хүчний систем ТӨХК, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Говь-Алтай дахь салбар, Авто тээврийн үндэсний төвийн Говь-Алтай дахь салбар, “Тайшир Гуулин” УЦС гэсэн 7 төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллага орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

Эдгээр нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд өөрийн нэрээр цэстэй, хуулийн үйлчлэлд бүрэн хамрагдаж байна.

Аудитад 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаарх мэдээллийг авч үзсэн болно.

- 6.1.1-т заасан мэдээллийн хувьд: Цахим хуудсанд 2018 оны жилийн төсвийг мэдээлэх 204 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд байгаагаас 33 байгууллага нь мэдээлээгүй бөгөөд 83 хувийн хэрэгжилттэй байна. Энэ нь өмнөх жилтэй харьцуулахад мэдээлээгүй байгууллага 18-аар буурсан үзүүлэлттэй байна. Мөн 7 ТӨҮГ-уудаас 4 байгууллага нь тухайн жилийн төсвөө /төлөвлөгөө/ мэдээлэх цэс нээлгээгүй байна. /”Тайшир-Гуулин” УЦС ХХК, Говь-Алтай “АЗЗА” ТӨХК, “Алтай-Улиастай” ЭХС ТӨХК, Говь-Алтай аймгийн Авто тээврийн төв/¹

Тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг мэдээлбэл зохих 22 байгууллагаас 19 байгууллага мэдээлж 3 байгууллага /Дэлгэр, Дарив сумууд, Есөнбулаг сумын 4-р цэцэрлэг/ нь мэдээлээгүй бөгөөд 86 хувийн хэрэгжилттэй байна. Өмнөх онтой харьцуулахад мэдээлээгүй байгууллага 2-оор нэмэгдсэн байна. Төрийн өмчит үйлдвэрийн газруудаас мэдээлбэл зохих 4 байгууллага худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг мэдээлсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөг мэдээлбэл зохих 20 байгууллагаас 18 байгууллага мэдээлж 2 байгууллага /Цогт, Дарив сум/ мэдээлээгүй бөгөөд 90 хувийн хэрэгжилттэй байна.

- 6.1.2-т заасан мэдээллийн хувьд: Аймгийн хэмжээнд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийг мэдээлбэл төрийн болон орон нутгийн өмчит 204 байгууллага байгаа бөгөөд тайлант хугацаанд 103,475.6 сая төгрөгийн гүйлгээг мэдээлэхээс хугацаанд нь 90,365.1 сая төгрөгийн, хугацаа хоцроож 5,664.5 сая төгрөгийн гүйлгээг мэдээлж 7,387.6 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй бөгөөд хэрэгжилт 92 хувьтай байна. */Дэлгэрэнгүй*

Төсвийн гүйцэтгэл /Дараа сарын 8-ны дотор мэдээлэх/		Мөнгөн дүн /мян.төг/	Байгууллагын тоо	
2017 он	10-р сар	мэдээлээгүй	377,393	31
	11-р сар	мэдээлээгүй	513,794	35
	12-р сар	мэдээлээгүй	972,234	33
2018 он	1-р сар	мэдээлээгүй	473,856	39
	2-р сар	мэдээлээгүй	675,632	42
	3-р сар	мэдээлээгүй	435,297	34
	4-р сар	мэдээлээгүй	510,375	33
	5-р сар	мэдээлээгүй	535,942	36
	6-р сар	мэдээлээгүй	827,316	31
	7-р сар	мэдээлээгүй	585,852	31
	8-р сар	мэдээлээгүй	864,038	45
	9-р сар	мэдээлээгүй	615,940	24
төсөв гүйцэтгэл	НИЙТ ДҮН	мэдээлээгүй	7,387,668	35

¹ Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралт “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын /4.1.2. төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын зорилтот түвшинг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт сар, улирал, хагас болон бүтэн жилийн мэдээг дараа сарын 8-ны дотор энэ журмын 17 дугаар хавсралтад заасан маягтын дагуу тус тус цахимаар;/


хавсралт №1-ээс үзнэ үү/

Төрийн өмчит үйлдвэрийн 7 газраас 3 газар /"Тайшир-Гуулин" УЦС ХХК, Говь-Алтай "АЗЗА" ТӨХК, "Алтай-Улиастай" ЭХС ТӨХК/ төсвийн гүйцэтгэлээ мэдээлээгүй байна. Энэ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1² дэх заалт, 6.1.2³ дахь заалтуудыг зөрчсөн байна.

➤ 6.1.1- 6.1.6-д заасан мэдээллийн хувьд:

Хуулийн 3.1.1 болон 3.1.2-т заасан 211 байгууллагаас 5 байгууллага хамааралгүй /Хилийн 0214-р анги, Цэргийн 304-р анги, "Тайшир-Гуулин" УЦС ХХК, Говь-Алтай "АЗЗА" ТӨХК, "Алтай-Улиастай" ЭХС ТӨХК/ буюу мэдээлэх шаардлагагүй байна. Төсвийн төслийг мэдээлбэл зохих 206 байгууллагаас 18 байгууллага хугацаа хоцорч мэдээлсэн, 44 байгууллага мэдээлээгүй бөгөөд хэрэгжилт 78.6 хувьтай, хагас жилийн санхүүгийн тайланг мэдээлбэл зохих 206 байгууллагаас 14 байгууллага хугацаа хоцорч мэдээлсэн, 22 байгууллага мэдээлээгүй бөгөөд хэрэгжилт 93.2 хувьтай, жилийн эцсийн санхүүгийн тайланг мэдээлбэл зохих 206 байгууллагаас 14 байгууллага хугацаа хоцорч мэдээлсэн, 39 байгууллага мэдээлээгүй бөгөөд хэрэгжилт 81 хувьтай, аудитын дүгнэлтийг мэдээлбэл зохих 206 байгууллагаас 15 байгууллага хугацаа хоцорч мэдээлсэн, 39 байгууллага мэдээлээгүй бөгөөд хэрэгжилт 82 хувьтай, аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 20 байгууллага хугацаа хоцорч мэдээлсэн, 83 байгууллага мэдээлээгүй бөгөөд хэрэгжилт 59.7 хувьтай, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг дунджаар 95 байгууллага мэдээлээгүй хэрэгжилт 45.6 хувьтай байна.

Төсвийн тухай хуульд төсвийн хүрээний мэдэгдлийг 4 сарын 15-ны дотор гаргахаар заасан байдаг гэтэл Шилэн дансны тухай хуульд энэ талаар оруулж өгөөгүй байна. Иймд төсвийн хүрээний мэдэгдлийг хууль болон журамд нэмэлтээр оруулж өгөх нь зүйтэй байна.

Дүрслэл № 1: Хуулийн 6.1.3-6.1.6-д заасан мэдээллийг мэдээлсэн байдал /тоо/


Өмнөх онтой харьцуулахад дээрх мэдээллийг мэдээлээгүй зөрчил бага зэрэг буурсан үзүүлэлттэй харагдаж байгаа хэдий боловч, зөрчил бүрэн

² Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:

³ хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор;

арилаагүй байгаа нь ажлын хариуцлагыг сайжруулаагүй, аудитаас гарсан шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж ажиллахгүй байгааг харуулж байна

Дүрслэл №2: Хуулийн 6.1.3-6.1.6-д заасан мэдээллийг мэдээлээгүй байгууллагын тоог өмнөх онтой харьцуулбал:



- 6.2.5-д заасан Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, тэдгээрийн задаргаа:

Мэдээлбэл зохих 35 байгууллагаас мэдээлээгүй 2 байгууллага байна. Үүнд: Дарив, Цогт сумууд

- 6.3.8-д заасан тусгай сангуудын орлого зарлагын талаар:

ОНХС-гаас бусад тусгай сангуудын гүйцэтгэлийг мэдээлэх цэс тусдаа байхгүйгээс орлого, зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.

Тухайлбал: СХС-гийн хувьд орлогын 440.8 сая төгрөг, зарлагын 340.6 сая төгрөг, ЭЭС-гийн хувьд орлогын 3.6 сая төгрөг, зарлагын 4.6 сая төгрөг, ОНХС-гийн хувьд орлогын 723.1 сая төгрөг, зарлагын 142.6 сая төгрөг, БХНСС-гийн хувьд орлогын 8.1 сая төгрөг, зарлагын 1.2 сая төгрөг нийт 1,664.6 сая төгрөгийг мэдээлээгүй байна

Хүснэгт №2: Сангуудын мэдээлэгдээгүй орлого, зарлага /сая төг/

Үзүүлэлт	СХС	ЭЭС	ОНХС	БХНСС	Дүн
Орлого	440.8	3.6	723.1	8.1	1,175.6
Зарлага	340.6	4.6	142.6	1.2	489.0
дүн	781.4	8.2	865.7	9.3	1,664.6

- Шилэн дансны тухай хуулийн 6.4–т заасан мэдээллүүдийг мэдээлсэн эсэхийг үзэхэд дараах байдалтай байна.

- 6.4.1-д заасан тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт: Аймгийн хэмжээнд 37 байгууллагын төсөвт өөрчлөлт орсон байна. Өөрчлөлт орсон эсэх талаар 207 байгууллага мэдээлж, 1 байгууллага мэдээлээгүй, 3 байгууллага хамааралгүй байна.

- 6.4.2-т заасан тухайн байгууллагын хууль, тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт 75 байгууллагад өөрчлөлт орж, 3 байгууллага мэдээлээгүй, хамааралгүй 136 байгууллага байна.

- 6.4.3-т Тендер худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээлэл: Төсөл сонгон шалгаруулалтад нийт 497 хуулийн этгээд, иргэд оролцон байх бөгөөд

- 472 оролцогчийг мэдээлж, 25 оролцогчийг 6 байгууллага мэдээлээгүй байна. Үүнээс шалгарсан 253 оролцогчоос 190 мэдээлж, 88 оролцогчийг 24 байгууллага мэдээлээгүй, шалгараагүй 226 оролцогчоос цахим хуудсаар 209 этгээдийг мэдээлж, 17 оролцогчийг 6 байгууллага мэдээлээгүй байна.
- 6.4.4-т Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл: Алтай сумын Дунд сургууль 7.1 сая төгрөг, Чандмань сум 25.7 сая төгрөг, Баянтоорой тосгоны Дунд сургууль 22.1 сая төгрөг, Цогт сумын Дунд сургууль 5.4 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэг 5.3 сая төгрөг, Төгрөг сум 7.9 сая төгрөг, Хөхморьт сум 36.9 сая төгрөг, Жаргалан сумын Хүүхдийн цэцэрлэг 5.4 сая төгрөг, Дарив сум 14.4 сая төгрөг, ЗДТГ 6.9 сая төгрөг, Дунд сургууль 15.2 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэг 5.3 сая төгрөг, Баян-Уул сумын Дунд сургууль 63.3 сая төгрөг, Бугат сумын Дунд сургууль 26.4 сая төгрөг, Эрдэнэ сумын Эрдэнэ Эрчим хүч 103.0 сая төгрөг, “Алтай” Нисэх буудал 6.9 сая төгрөг, АШУҮИС-ийн ГАА дахь салбар 28.0 сая төгрөг нийт 385.6 сая төгрөгийн 41 худалдан авалтыг 32 байгууллага мэдээлээгүй, 1,143.2 сая төгрөгийн 122 худалдан авалтыг мэдээлсэн бөгөөд хуулийн хэрэгжилт 23 хувьтай буюу хангалтгүй байна. Өмнөх онд энэ зөрчил гараагүй байна.
 - 6.4.5-д заасан Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын мөнгөн гүйлгээ: Аймгийн хэмжээнд нийт 564 удаагийн зарлагын гүйлгээ гарснаас 26,474.8 сая төгрөгийн 455 гүйлгээг мэдээлж 1,397.9 сая төгрөгийн 109 удаагийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна. Орлогын 20,267.5 сая төгрөгийн 172 удаагийн гүйлгээ хийгдсэнээс 21 удаагийн 211.3 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна.
 - 6.4.6-д заасан худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнд аймгийн хэмжээнд хяналт шалгалт хийгээгүй байна.
 - 6.4.7-д заасан байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт: Аймгийн хэмжээнд 22 байгууллагын бүтэц, орон тоонд өөрчлөлт орсон бөгөөд бүрэн мэдээлсэн байна.
 - 6.4.8-д заасан байгууллагын даргын өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэхтэй холбоотой шийдвэр: Аудитад хамрагдсан байгууллагуудын тушаалыг шилэн дансанд мэдээлсэн тушаалтай тулган баталгаажуулахад мэдээлэх ёстой 4293 тушаал шийдвэрийг мэдээлэхээс 1,902.6 сая төгрөгийн 1898 тушаал шийдвэрийг мэдээлээгүй байна. Аудитаар Эрдэнэ “Эрчим хүч” ОНӨААТҮГ, ГИДЦГ-ын Б хэсгийн хамгаалалтын захиргаа, Цогт сумын Эрүүл мэндийн төв, Баянтоорой тосгоны Эрүүл мэндийн төв тушаал шийдвэрээ хамруулаагүй болно. Мөн Зэвсэгт хүчний 304-р анги, Хилийн 0214-р ангийн тушаал шийдвэр төрийн нууцад хамаарах тул цахим хуудсаар мэдээлэх боломжгүй байна. Тодруулга: Тушаал шийдвэрийг файлаар цахим хуудсанд байршуулаагүй тохиолдолд мэдээлээгүй гэж авсан болно.

Хүснэгт №3: Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл

/сая.төгрөгөөр/

Ангилал	Байгууллагын тоо	Нийт шийдвэрийн тоо	Үүнээс: мэдээлсэн тоо	Мэдээлэх мөнгөн дүн	Мэдээлээгүй тоо	Мэдээлээгүй мөнгөн дүн
Улсын төсөвт	35	273	177	296.5	96	103.6

хуулийн этгээд						
Орон нутгийн төсөвт хуулийн этгээд	164	3,671	1,930	3,605.9	1741	1,268.5
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	5	18	18	5,125.0	0	0
Төрийн өмчит үйлдвэрийн газар	7	331	260	1,480,1	61	529.5
Нийт	211	4293	2385	10,507.5	1,898	1,902.6

➤ 6.4.9-д заасан хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл: Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 6.2.1-д тодорхойлсон үзүүлэлт, хүрэх үр дүн, хэрэгжилтийг хэмжих тоон болон чанарын үзүүлэлтийг “Говь-Алтай аймаг” цэсэнд мэдээлсэн байна


➤ Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан зарим байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.4-д заасан мэдээллийг хугацаанд нь тогтмол мэдээлсэн эсэхийг нотлох боломжгүй, мэдээллийг дутуу, зөрүүтэй мэдээлжээ. /Дэлгэрэнгүйг хавсралт №2-ээс үзнэ үү/

1.2 Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчид шилэн дансны мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт 43 хувьтай мэдээлжээ.

Говь Алтай аймаг болон сумдын нэгдсэн цахим хуудсанд мэдээлсэн мэдээллүүдийг мэдээллийн самбарт мэдээлсэн эсэхийг үзэхэд: 50%-иас доош мэдээлсэн Бигэр, Дэлгэр, Халиун, Хөхморьт, Цогт, Цээл, Чандмань, Эрдэнэ, Есөнбулаг сумууд байна. . /Дэлгэрэнгүйг хавсралт №3-ээс үзнэ үү/

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7⁴ дахь заалтыг зөрчсөн байна.

Дүрслэл № 3: Мэдээллийн самбарт мэдээлсэн судалгаа



1.3 Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэхийг ҮАГ дээр авч үзнэ.

⁴ Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна.

БҮЛЭГ II: ХУУЛИЙН 3.1.4-Д ЗААСАН БАЙГУУЛЛАГЫН 84 ХУВЬ НЬ САНХҮҮЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДСАНД МЭДЭЭЛСЭН, 3.1.5-Д ЗААСАН БАЙГУУЛЛАГУУДЫН 80 ХУВЬ НЬ ХАМРАГДАЖ, МЭДЭЭЛЛИЙН 68 ХУВИЙГ МЭДЭЭЛСЭН БАЙНА.

2.1 Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани байхгүй.

2.2 Хуулийн 3.1.4 буюу улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа ААНБ-ийн 84 хувь нь санхүүжүүлэгч байгууллагын цахим хуудсанд мэдээлсэн, 16 хувь нь мэдээлээгүй байна.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасан иргэн, ААНБ аймгийн хэмжээнд 57 байгууллага 10.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй төсөл хөтөлбөр, арга хэмжээ гүйцэтгэж байна. Эдгээр байгууллагуудаас 9 байгууллага мэдээлээгүй, 48 байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд бие даасан мэдээлэл байршуулах цэсгүй бөгөөд зөвхөн санхүүжүүлэгч байгууллага өөрийн хуудсанд мэдээлж байна.⁵ /Дэлгэрэнгүйг хавсралт №4 -өөс үзнэ үү/

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсэг, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ажил үйлчилгээ, гүйцэтгэгч байгууллага, нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийг улирал тутам мэдээлэхээр заасан боловч цахим хуудсанд бүрэн мэдээлэх цэс үүсгээгүй байна

2.3 Хуулийн 3.1.5 буюу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчид шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 80 хувьтай хамрагдаж, хуульд заасан мэдээллийг 68 хувьтай мэдээлсэн байна.

Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж гэрээний үндсэн дээр гүйцэтгэж байгаа 5 байгууллага байгаа бөгөөд “Оюуны өргөө” бага сургууль цахим хуудас нээлгэсэн боловч, доторх мэдээлэл тавих цэс байхгүй. /Дэлгэрэнгүйг хавсралт №5-аас үзнэ үү/

- 6.1.1-д заасан мэдээлэл: Батлагдсан төсвийг 4 байгууллага бүрэн мэдээлсэн. Төсвийн гүйцэтгэл 372.1 сая төгрөгийг мэдээлэхээс 339.2 сая төгрөгийг хугацаанд нь мэдээлж, 32.9 сая төгрөгийг хугацаа хоцорч мэдээлсэн.
- 6.1.6-д заасан Хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбар: Хэтэрсэн, хэмнэсэн зардлын шалтгаан тайлбарыг аль ч байгууллага мэдээлээгүй байна.

⁵ Хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 /Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй./

- 6.1.3-6.1.6-д заасан мэдээлэл: Ахмадын хороо нь төсвийн төсөл, хагас жилийн санхүүгийн тайлан, жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг мэдээлээгүй, бусад 3 байгууллага хугацаанд нь мэдээлжээ.
- 6.4.1-6.4.7-д заасан мэдээлэл: Тухайн байгууллагуудын төсөвт өөрчлөлт ороогүй, 5.0 сая төгрөгөөс дээш худалдан авалт, орлого зарлагын гүйлгээ гараагүй, тендер худалдан авалт байхгүй, батлагдсан орон тоонд өөрчлөлт ороогүй, бусад байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй бөгөөд цахим хуудсандаа энэ талаар мэдээлсэн байна.
- 6.4.8-д Төсөв, өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэр: Мэдээлэх ёстой 787.9 сая төгрөгийн 15 тушаал шийдвэрээс 11 тушаал шийдвэрийг мэдээлж, 0.8 сая төгрөгийн 4 тушаал шийдвэрийг мэдээлээгүй байна. Эдгээр 4 тушаал шийдвэрийг “Марал-Алтай” ӨЭМТ байна.

Хуулийн хэрэгжилтийг хангалтгүй хэрэгжүүлсэн албан тушаалтнуудад сахилгын шийтгэл ногдуулах саналыг хүргүүлэхдээ шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт мэдээлэлийг 50%-иас доош оруулсан байгууллагын дарга, нягтлан бодогч нарыг хамруулсан. Эдгээр албан тушаалтнаас бусад хяналтын байгууллагаас сахилгын шийтгэл ногдуулсан албан тушаалтнуудыг хасаж оруулсан.

БҮЛЭГ III: БҮХ ШАТНЫ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ, САНХҮҮ ХЯНАЛТ АУДИТЫН АЛБА ЦАХИМААР ХЯНАЛТ ХИЙСЭН БОЛОВЧ ЗӨРЧИЛ АРИЛААГҮЙ, ДАВТАН ГАРСААР БАЙНА.

3.1 Хуулийн 8.1 буюу бүх шатны ИТХ-ийн хяналт хийгээгүй, хуулийн 8.2-т заасан Санхүү, хяналт аудитын албан хяналтыг цахимаар хэрэгжүүлж, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг хүргүүлсэн боловч хэрэгжилт 47.9 хувьтай хангалтгүй байна.

Аймгийн хэмжээнд 10 сумдын ИТХ шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 12 удаа хяналт хийсэн гэх боловч үнэлэлт, дүгнэлт өгөөгүй, хурлын тэмдэглэл, өгсөн шийдвэр байхгүй, хяналт тавьж ажилласан эсэхийг нотлох баримтгүй байна. */Дэлгэрэнгүйг хавсралт №6-аас үзнэ үү/*

Орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагаас нэгжийн аудит хийх тутамдаа тус байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт хийн тайланд тусгаж байгаа боловч шийдвэр өгөгдөөгүй. Учир нь жил бүр нэгдсэн журмаар хийдэг Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд нийцлийн аудитаар шийдвэр гаргаж байна.

Шилэн дансны тухай хуулийн 8.2⁶, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын алба дотоод хяналтын хэрэгжүүлж байна.

Тус албанаас 2018 оны 1, 2-р улирлын байдлаар хийсэн шалгалтаар мэдээлэх ёстой 13789 мэдээллээс 1378 мэдээлэл хугацаа хоцорч, 303 мэдээллийг огт мэдээлээгүй бөгөөд 48 албан тушаалтанд хариуцлага тооцож ирүүлэхийг дээд шатны албан тушаалтнуудад хүргүүлсэн байна. Хариуцлага тооцуулахаар хүргүүлсэн албан тушаалтнуудаас 23 албан тушаалтанд хариуцлага тооцон, хариу ирүүлсэн байна.

⁶ Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ.

Хуулийн хэрэгжилтийг хангуулахаар сургалт хийхээс гадна “Шилэн дансаа шижигнүүлцгээ” нэртэй бүлгэм нээж, шаардлагатай мэдээллийг тухай бүр байршуулсан байна.

Шилэн дансны цахим хуудсанд тухайн сар мэдээлсэн байдлаар харагдаж байгаа боловч тухайн мэдээллийг дэлгэрэнгүй үзэхээр нэвтэрч ороход “мэдээлэл байхгүй” хэмээн тэмдэглэл хийсэн байна. Гэтэл Санхүүгийн хяналт, аудитын албанаас ирүүлсэн ажлын тайлангийн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт-хугацаагаар /2018 оны 2 дугаар улирал/ аймгийн хэмжээнд 92.8 хувийн хэрэгжилттэй байна гэжээ.

Нэгж байгууллагын дансны хуулга, тушаал шийдвэр бусад баримтыг тулган хяналт хийгээгүй, цахимаар хийсэн нь мэдээллийг буруу зөрүүтэй мэдээлэх, мэдээлэх мэдээлэл байсан ч оруулаагүй зэрэг зөрчил давтан гарсаар байна.⁷

Иймд хуулийн хэрэгжилтийг хангуулахын тулд нэгж байгууллагын баримт материалыг үндэслэн, цахим хуудсанд мэдээлсэн мэдээлэлтэй тулгаж хяналт хийх шаардлагатай байна.

3.2 Хуулийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд цахимаар хяналт хийсэн боловч үр дүнгүй байна.

Аймгийн хэмжээнд хуулийн 3.1.3-т заасан байгууллага байхгүй, Санхүү, хяналт аудитын албанаас 3.1.4-т заасан Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа ААНБ-ууд болон хуулийн 3.1.5-д заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 5 байгууллага байгаагаас цахимаар хяналтыг бүрэн хэрэгжүүлжээ.

Аудитаар 3.1.4-т заасан байгууллагуудын 16 хувь мэдээлээгүй, 3.1.5-д заасан байгууллагууд мэдээллийг 68 хувьтай мэдээлжээ.

Санхүү хяналт, аудитын алба нь цахимаар хяналт хийж байгаа боловч, мэдээлэлийг бүрэн мэдээлэхгүй, дутуу зөрүүтэй мэдээлсэн зэрэг нь хяналт үр дүн муутай хийгдэж байгааг харуулж байна.

3.3 Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаар иргэд, олон нийт мэдэхгүй, энэ талаарх мэдээлэл дутмаг байна.

Иргэдээс орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагад шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээлэл тус хуулийн мөрдөгдөж эхэлсэн хугацаанаас хойш ирүүлээгүй байна.


Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дэргэдэх “Иргэдийн бүлэг”-тэй хамтран иргэд, олон нийтээс санал асуулга авахад:

- Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа ил тод гэж боддог уу гэсэн асуултад 10 хувь ил тод, 52 хувь нь ил тод биш, 38 хувь нь мэдэхгүй
- Та төрийн байгууллагуудаас ямар нэгэн мэдээлэл авч байсан уу гэсэн асуултад 33 хувь нь тийм, 67 хувь нь үгүй
- Та шилэн дансны тухай хуулийн талаар мэдэх үү гэсэн асуултад 18 хувь нь тийм, 82 хувь нь үгүй

⁷ Говь-Алтай аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2017 оны 10 сарын 30-ны өдрийн байдлаарх “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, түүнд хяналт хийх чиглэлээр хийсэн ажлын тайлан”

- Та www.shilendans.gov.mn сайтад хандаж мэдээлэл авч байсан уу гэсэн асуултад 2 хувь нь тийм, 98 хувь нь үгүй гэж тус тус хариулжээ.

Дүрслэл №4: Иргэдээс авсан санал асуулгын нэгтгэл



Санал асуулгын үр дүнгээс харахад манай аймагт шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар иргэд олон нийтийн мэдлэг, мэдээлэл дутмаг байгаа нь хуулийн талаар сургалт сурталчилгаа хийдэггүйтэй холбоотой байна.

3.4 Зөрчил давтан гарсаар байгаа нь өмнөх шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Манай байгууллага нь тус хуулийн хэрэгжилтэд 2015 онд хийсэн аудитаар 4,071.4 сая төгрөг, 2016 оны эхний 1 дүгээр улирлын байдлаар хийсэн аудитаар 2,540.6 сая төгрөг, 3 дугаар улирлын байдалд хийсэн аудитаар 5,924.4 сая төгрөг, 2017 оны 3 дугаар улирлын байдлаар хийсэн аудитаар 12,150.3 сая төгрөгийн зөрчил илрүүлэн холбогдох шийдвэрийг албан тушаалтанд хүргүүлсэн байна.

2017 оны нийцлийн аудитаар 28 албан тушаалтанд хариуцлага тооцох санал хүргүүлсэн бөгөөд аймгийн Засаг даргын 2018 оны 06 сарын 18-ны өдрийн 1/783 болон 1/784 дүгээр албан бичгээр 26 байгууллагын дарга, нягтлан бодогч нарт хариуцлага тооцсон гэж хариу ирүүлсэн боловч тухайн албан тушаалтанд хариуцлага тооцсон эсэхийг нотлох боломжгүй байна.

Санхүү хяналт, аудитын албаны албан тоотоор шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар өгөгдсөн шийдвэрийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээллийг ирүүлсэн байна. Үүнд:


1. Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын шилэн дансыг цахимаар хянаж 48 албан тушаалтанд хариуцлага тооцох санал хүргүүлсэн, хэрэгжилт 47.9 хувьтай
2. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх бүртээ шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллаж байна.
3. Шилэн дансны тухай хуулиар сургалт хийж, бүлгэм нээн ажиллуулсан байна.

Гэвч дээрх аудитудаар илэрсэн зөрчил жил бүр дахин давтан гарсаар байна.

Дүрслэл 5: Сүүлийн 3 жилийн зөрчлийг харьцуулсан судалгаа /тоогоор/



Дүрслэл 6: Сүүлийн 3 жилийн зөрчлийг харьцуулсан судалгаа /сая.төгрөг/



Өмнөх шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах талаар ажил зохион байгуулж хяналт шалгалт хийсэн боловч, үр дүн нь хангалтгүй өмнөх аудитаар илэрсэн зөрчил дахин давтан гарсаар байна.

Аудитаар дараах зөрчлүүд илэрлээ.

Аудитаар нийт 9,792.5 сая төгрөгийг зөрчлийг илрүүлэн 3 заалт бүхий зөрчил арилгуулах албан шаардлага, 2 заалт бүхий зөвлөмж, Үндэсний аудитын газарт 1 заалттай саналыг хүргүүллээ.

1. Цахим хуудсанд 2018 оны жилийн төсвийг 33 байгууллага нь мэдээлээгүй, тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 3 байгууллага мэдээлээгүй, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөг 2 байгууллага байна.
2. Аймгийн хэмжээнд сар, улирал, хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг 12 байгууллага, сан хугацаа хоцроож 5,697.8 сая төгрөгийн гүйлгээг мэдээлж 35 байгууллага, сан 7,387.6 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна.
3. Аймгийн хэмжээнд 2019 оны төсвийн төслийг 18 байгууллага хугацаа хоцорч мэдээлсэн, 45 байгууллага мэдээлээгүй байна.
4. Аймгийн хэмжээнд 2018 оны хагас жилийн санхүүгийн тайланг 14 байгууллага хугацаа хоцорч мэдээлсэн, 23 байгууллага мэдээлээгүй, 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 14 байгууллага хугацаа хоцорч мэдээлсэн, 40 байгууллага мэдээлээгүй байна.

5. Аймгийн хэмжээнд 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 15 байгууллага хугацаа хоцорч мэдээлсэн, 40 байгууллага мэдээлээгүй, аудитын тайлан дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 20 байгууллага хугацаа хоцорч мэдээлсэн, 84 байгууллага мэдээлээгүй байна.
6. Аймгийн хэмжээнд 2017 оны 4 дүгээр улиралд 110 байгууллага, сан, 2018 оны 1 дүгээр улиралд 99 байгууллага, сан, 2 дугаар улиралд 95 байгууллага, сан, 3 дугаар улиралд 93 байгууллага, сан төсвийн хэмнэлт, хэтрэлтийн шалтгаан тайлбарыг дунджаар 95 байгууллага мэдээлээгүй байна.
7. Аймгийн хэмжээнд улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын гүйцэтгэлийн 2 байгууллага мэдээлээгүй байна.
8. Аймгийн хэмжээнд СХС-ийн 440.8 сая төгрөгийн орлогын гүйцэтгэлийг 8 сум, 340.6 сая төгрөгийн зарлагын гүйцэтгэлийг 7 сум мэдээлээгүй байна.
9. 10 сумын эргэлтийн эмийн сан орлогын болон зарлагын гүйцэтгэлээ мэдээлээгүй байна.
10. ОНХС-ийн 723.1 сая төгрөгийн орлогыг 6 сум, 142.6 сая төгрөгийн зарлагыг 4 сум мэдээлээгүй байна.
11. БХНСС-ийн 8.1 сая төгрөгийн орлогыг 4 сум, 1.17 сая төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.
12. 2018 оны төсөвт нэмэлт орсон нэмэлт өөрчлөлтийг 1 байгууллага мэдээлээгүй байна.
13. Байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр хураамж, үйлчилгээний хөлсөнд орсон өөрчлөлтийг 3 байгууллага мэдээлээгүй байна.
14. Тендер худалдан авалттай холбоотой 36 оролцогчтой холбоотой мэдээллийг мэдээлээгүй байна.
15. Таван сая төгрөгөөс дээш худалдан авалтын 385.6 сая төгрөгийн 41 гүйлгээг мэдээлээгүй байна.
16. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн 1,397.9 сая төгрөгийн 109 гүйлгээг, орлогын 211.3 сая төгрөгийн 21 гүйлгээг мэдээлээгүй байна.
17. Аймгийн хэмжээнд төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 1,902.5 сая төгрөгийн 1902 тушаал шийдвэрийг мэдээлээгүй байна.
18. Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр 301.7 сая төгрөгийн гэрээт ажил улс, орон нутгийн төсөв, ОНХС-ийн хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээ хэрэгжүүлж буй 9 иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг мэдээлээгүй байна.
19. Бүх шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурал, иргэдийн Нийтийн хурлаас шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй, нотлох баримтаар баталгаажуулаагүй байна.
20. Аудитаар бодит байдалтай танилцахад Баян-Уул сумын Сум дундын эмнэлэг, Баян-Уул сумын Засаг дарга, Дэлгэр сумын Засаг дарга, ИТХ, ЗДТГ, сургууль, цэцэрлэг, ЭМТ, соёлын төв, эргэлтийн эмийн сан, Гуулин тосгоны захирагч, сургууль, цэцэрлэг, ЭМТ, Соёлын төв, Жаргалан сумын ИТХ, ЗДТГ, сургууль, цэцэрлэг, Тайшир сумын эргэлтийн эмийн сан, ЗДТГ, сургууль, соёлын төв, Цогт сумын ЗДТГ, сургууль, цэцэрлэг, ЭМТ, Соёлын төв, Есөнбулаг сумын 7-р цэцэрлэг, Чандмань сумын соёлын төв, Баянтоорой тосгоны сургууль, цэцэрлэг, соёлын төв, ЭМТ, Бугат сумын Тахийн тал бага сургууль, Дарви сумын Засаг дарга, ЗДТГ, ЭМТ, Тонхил

- сумын Засаг дарга, эргэлтийн эмийн сан, Төгрөг сумын Засаг дарга, сургууль, цэцэрлэг, соёлын төв, ИТХ, Цээл сумын сургууль, Хөхморьт сумын сургууль, соёлын төв, ЭМТ, Стандартчлал хэмжил зүйн хэлтэс, Радио телевизийн сүлжээний газар нь 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2018 оны 09 дүгээр сарын 31-ний өдрийн хооронд шилэн дансны тухай хуульд заасан мэдээлэх үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн, мэдээллээ хугацаа хоцорч байршуулсан, мэдээллээ байршуулаагүй зэрэг зөрчлийг удаа дараа гаргаж хуулийг хангалтгүй хэрэгжүүлж байгаа зөрчил илэрлээ.
21. Төрийн өмчит үйлдвэрийн 7 газраас 3 газар /"Тайшир-Гуулин" УЦС ХХК, Говь-Алтай "АЗЗА" ТӨХК, "Алтай-Улиастай" ЭХС ТӨХК/ төсвийн гүйцэтгэл, 6.1.3-6.1.6-д заасан мэдээллүүдийг мэдээлэх цэс байхгүй байна.
22. Аймгийн тариалан эрхлэлтийн дэмжих санд 52,029.4 мянган төгрөгийн, мал хамгаалах санд 167,013.0 мянган төгрөгийн, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд 46,088.1 мянган төгрөгийн нийт 265,130.5 мянган төгрөгийн орлогын гүйлгээ гарсан боловч шилэн дансны цахим хуудсанд цэс нээгдээгүй тул мэдээлээгүй байна.

**ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:
АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТ 69%-ТАЙ БАЙНА.**

ДАРГА , ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

ДЭЭРХ ДҮГНЭЛТЭД ҮНДЭСЛЭН ДАРААХ ШИЙДВЭРИЙГ ГАРГАЖ БАЙНА.**САНАЛ**

Үндэсний аудитын газарт

- Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн цэсийг бүрэн нээлгэх
- Говийн их дархан цаазат газрын А хэсгийн хамгаалалтын захиргааны дарга Ч.Баярбатад хуулийн дагаа сахилгын шийтгэл ногдуулах.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг дарга С.Гансэлэм

- Улс, орон нутгийн төсөв, ОНХС-аас төсөл хөтөлбөр сонгон шалгаруулах, гэрээ байгуулахдаа шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулах тухай шалгуур үзүүлэлтийг тусгах

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Т.Ганзориг

- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавьж ажиллах

ЗӨРЧИЛ АРИЛГАХ АЛБАН ШААРДЛАГА

Аймгийн Засаг дарга С.Гансэлэм

- Аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллан, түүнд хяналт тавьж ажиллах.
- Цахим хуудсанд цэс нээж, олон нийтэд ил тод мэдээлэх

САХИЛГЫН ШИЙТГЭЛ НОГДУУЛАХ АЛБАН ШААРДЛАГА

- Дараах байгууллагын дарга нарт хариуцлага тооцуулах

Аймгийн Засаг дарга С.Гансэлэмд доорх нэр бүхий албан тушаалтнуудад хуулийн дагуу сахилгын шийтгэл ногдуулах

дд	Албан байгууллага	Албан тушаал	Овог нэр
1	Стандарт хэмжил зүйн хэлтэс	Дарга	Г.Ариунболд
2	Баян-Уул сум	Засаг дарга	Э.Нямбаатар
3	Бигэр сум	Засаг дарга	Ш.Лхаасүрэн
4	Дэлгэр сумын Эрүүл мэндийн төв	Дарга	Г.Болдбаатар
5	Гуулин тосгоны Эрүүл мэндийн төв	Дарга	Б.Эрдэнэчимэг
6	Жаргалан сум	Засаг дарга	Д.Баярсайхан,
7	Жаргалан сумын Хүүхдийн цэцэрлэг	Эрхлэгч	Э.Энхтуяа
8	Цогт сум	Засаг дарга	Л.Насанбуян
9	Цогт сумын Эрүүл мэндийн төв	Дарга	Б.Дашдондог
10	Есөнбулаг сум	Засаг дарга	Ш.Дагва
11	Есөнбулаг сумын 7-р цэцэрлэг	Эрхлэгч	Ж.Уранчимэг

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Т.Ганзориг

- Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга А.Мөнхтөрд сахилгын шийтгэл оногдуулах

Дарив сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга О.Баянмөнхөд

- Дарив сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга Д.Тунгалагт сахилгын шийтгэл оногдуулах

Дэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Г.Баасанмаад

- Дэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга Ч.Эрдэнэбулганд сахилгын шийтгэл ногдуулах

Чандмань сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Н.Сутайд

- Чандмань сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга Д.Баасанжаргалд сахилгын шийтгэл ногдуулах
- Чандмань сумын Засаг дарга Н.Давгадоржид
- ЗДТГ-ын дарга Ж.Самбууд сахилгын шийтгэл оногдуулах
 - Соёлын төвийн эрхлэгч Ц.Лханаажавт сахилгын шийтгэл оногдуулах
- Дэлгэр сумын Засаг дарга С.Уранчимэгт
- Дэлгэр сумын Засаг даргын тамгын газрын дарга Р.Балжиннямд сахилгын шийтгэл оногдуулах
 - Дэлгэр сумын Гуулин багийн Засаг дарга А.Пүрэвдоржид сахилгын шийтгэл оногдуулах
 - Дэлгэр сумын Соёлын төвийн эрхлэгч Н.Нарантуяад сахилгын шийтгэл оногдуулах
- **Дараах байгууллагын санхүүгийн албаны дарга, нягтлан бодогч нарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.**
- Баян-Уул сумын Засаг дарга Э.Нямбаатарт
- Шилэн дансны тухай хуульд заасан мэдээлэх үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн санхүүгийн албаны дарга Д.Наранчимэгт сахилгын шийтгэл оногдуулах
- Бигэр сумын Засаг дарга Ш.Лхаасүрэнд
- Шилэн дансны тухай хуульд заасан мэдээлэх үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн санхүүгийн албаны дарга Х.Мөнхбаярт сахилгын шийтгэл оногдуулах
- Есөнбулаг сумын Засаг дарга Ш.Дагвад
- Шилэн дансны тухай хуульд заасан мэдээлэх үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн санхүүгийн албаны дарга Д.Бадамханд сахилгын шийтгэл оногдуулах
- Цогт сумын Гуулин тосгоны засаг дарга А.Пүрэвдоржид
- Шилэн дансны тухай хуульд заасан мэдээлэх үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн төрийн сангийн төлөөлөгч Н.Бүдлхамд сахилгын шийтгэл оногдуулах
- Эрдэнэ Эрчим хүч ОНӨААТҮГ –ийн захирал А.Мягмаржавт
- Шилэн дансны тухай хуульд заасан мэдээлэх үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн нягтлан бодогч Х.Дүгэрсүрэнд сахилгын шийтгэл оногдуулж
- Есөнбулаг сумын 7-р цэцэрлэгийн эрхлэгч Ж.Уранчимэгт
- Шилэн дансны тухай хуульд заасан мэдээлэх үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн нягтлан бодогч Б.Эрдэнэчулуунд сахилгын шийтгэл оногдуулж

Холбогдох байгууллагын санал